



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 14 өдөр

Дугаар А/14

Мөрөн сум

Арга хэмжээг хэрэгжүүлэх төсөвт
өртөг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.3, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.6, 65 дугаар зүйлийн 65.1.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн ээлжит IX хуралдааны 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны ээлжит IX хуралдааны 05 дугаар тогтоолын 04 дүгээр хавсралтад батлагдсан “Зөв төлөвлөлт-Өгөөжтэй эдийн засаг” арга хэмжээгээр хэрэгжих ажлын жагсаалт, төсөвт өртгийг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулах болон шаардлагатай нөхцөлд зөвлөмж ирүүлж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Должинсорогдог)-д даалгасугай.

3. Дээрх арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах 46,209,000 (Дөчин зургаан сая хоёр зуун ес) төгрөгийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн батлагдсан төсвөөс холбогдох хууль журамд нийцүүлэн, арга хэмжээний гүйцэтгэлээр санхүүжүүлэх, төлөвлөгдсөн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж, хэрэгжилтийг тухай бүр тооцож, тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Оюунтуяа), Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Базар) нарт тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Аймгийн Засаг даргын 2022 оны
01 дүгээр сарын 14-ны өдрийн А/14 дугаар
захирамжийн хавсралт

“ЗӨВ ТӨЛӨВЛӨЛТ-ӨГӨӨЖТЭЙ ЭДИЙН ЗАСАГ”
АРГА ХЭМЖЭЭГЭЭР ХЭРЭГЖИХ АЖЛЫН ЖАГСААЛТ,
ТӨСӨВТ ӨРТӨГ

№	Хөтөлбөрт тусгагдсан зорилт	Шаардагдах зардал	Хариуцах хэлтэс
1	Төрийн сангийн дотоод хяналтын хэрэгжилтийг эрчимжүүлэх	3,000,000	Санхүү, төрийн сангийн хэлтэс
2	Санхүүгийн ажилтнуудын техник хэрэгслийг үе шаттайгаар шинэчлэх	39,209,000	Санхүү, төрийн сангийн хэлтэс
4	Худалдан авах ажиллагаанд оролцогч талууд болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, иргэдийн төлөөллийг худалдан авах ажиллагааны суурь мэдлэг олгох сургалтад хамруулах замаар тэдний санхүүгийн мэдлэг чадварыг дээшлүүлнэ	4,000,000	Орон нутгийн өмчийн газар
Нийт дүн		46,209,000	

___оОо___